



СУРАЛЦАГЧДЫН ХИЧЭЭНГҮЙ БИЧИХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ (МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн 2-3 дугаар курсийн оюутнуудын жишээн дээр)

Б.Мөнхтуяа^а, Б.Наранчимэг^б

^аМУБИС-Архангайн Багшийн сургууль, багш, дэд профессор;

^бМУБИС-Архангайн Багшийн сургууль, багш, магистр

Холбоо барих зохиогч: b_munkhtuya@msue.edu.mn

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

Хураангуй

Багш бэлтгэдэг сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд “Хичээнгүй бичиг” хичээлээр “Оюутны эзэмшвэл зохих хичээнгүй бичгийн арга зүйн бэлтгэлийн баталгаат түвшинг хангах, сургалтдаа бичүүлж сургах аргуудыг бүтээлчээр хэрэглэдэг багш бэлтгэхэд оршино.” гэсэн зорилгыг дэвшүүлсэн байдаг. Оюутны эзэмших мэдлэг (хичээнгүй бичих журам, хичээнгүй бичиж сургах дотоод, гадаад хүчин зүйлийг ухааран ойлгох, хичээнгүй бичиж сурах аргуудыг эзэмших, үсэг бүтээх үндсэн зурлагыг зөв нэрлэж сурах, түүнийг хэрэглээ болгох), чадвар дадал (үндсэн 24 зурлагыг элемент болон самбарт хичээнгүй, зөв бичиж, түүнийг хэрэглээ болгох, цагаан толгойн 35 үсгийг зурлагаар нь төрөлжүүлэн бүлэглэн, зөв нэрлэх, элемент болон самбарт хичээнгүй бичих, үе, үг, өгүүлбэр, эх хичээнгүй бичих, самбарт дэгийн дагуу бичих аргачлал), хандлага (аливаад нухацтай, нямбай хандах арга ажиллагаанд суралцах, хичээнгүй бичих чадварт суралцаж, бичих чадвараа хөгжүүлэх эрмэлзэлтэй болох, суралцагч нэг бүртэй ганцаарчлан ажиллах арга зүйг ойлгож, ухамсарлах) –ыг төлөвшүүлэх зорилготой туршилт судалгааны үр дүнг үзүүлж байна. Өнөөгийн сургалтад хичээнгүй сайхан бичүүлэх арга зүйн асуудлыг нарийвчлан боловсруулж бичсэн ном гарын авлага ховор, зөвхөн хичээнгүй бичихэд холбогдох “Хичээнгүй бичиг” –ийн дэвтрүүд хэвлэгдэн гарах төдийгөөр хязгаарлагдаж байгаа энэ үед, багш мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын хичээнгүй бичих чадварыг хөгжүүлэх ямар боломжийг туршилт судалгаа хийж, үр дүнг тооцохыг зорилоо.

Түлхүүр үг

Оюутан, хичээнгүй бичиг, бичих чадвар, туршилт, ахиц

Удиртгал

Судалгааны зорилго

Туршилт судалгааны ажлын хүрээнд оюутан суралцагчдын хичээнгүй бичих чадвар дадлыг хөгжүүлэх, суралцах үйл ажиллагааг дэмжих зорилго дэвшүүлсэн.

Судалгааны үндэслэл

Багш, бага боловсролын сургалтын төлөвлөгөөнд “Хичээнгүй бичиг” хичээл 2 кредитээр 2-р курсийн намрын улиралд судлахаар тусгагдсан байдаг. Тухайн хичээлийг судлах явцад суралцагчдын хичээнгүй бичих чадвар нь жигдрээд сайхан бичдэг болдог хэдий ч “Туршин заах дадлага” болон 4-р курсийн “Багшлах дадлага”-д гарах үед хичээнгүй бичих чадвар буурсан байдаг. Тиймээс, оюутнууд бие даан хичээнгүй бичих чадвараа хөгжүүлэх шаардлагатай байна.

Хичээнгүй сайхан бичүүлж сургах нь бичгийн хэлний соёлд сургаж байгаа томоохон ажлын нэг хэлбэр бөгөөд багш боловсролыг эзэмшиж буй оюутан суралцагчдад хичээнгүй зөв сайхан бичих чадварыг бие даан эзэмшихэд чиглэсэн арга зүйн боловсруулалт бүхий сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн байх хэрэгцээ шаардлага тавигдаж байна.

Судалгааны ажлын шинэлэг тал

Суралцагчдын хичээнгүй бичих чадвар дадлыг хөгжүүлэх боломж, арга замыг судалж, “Хичээнгүй бичиг” клубийн үйл ажиллагаанд түшиглэж, бие даан суралцах чадварыг дэмжсэн шинэлэг судалгаа болсон.

Сэдвийн судлагдсан байдал

Эрдэмтэн Цэдэнбал.Ч, Бямбацэрэн.Г(2010) “Бага боловсролын монгол хэл, бичиг, уран зохиолын онол, дидактик” сурах бичгийн “Хичээнгүй бичиг” хэсэгт “Монгол хэлний дидактик” хичээлийн гол цөм хэсэг нь хичээнгүй бичиг, бичүүлж сургах арга зүй юм” гэж онцлон, хичээнгүй бичигт сургах тодруулан бичих, төрөлжүүлэн бүлэглэх, шугамын арга, тооллын арга, баримжааллын аргын талаар дэлгэрэнгүй дурдаж, цаашлаад хичээнгүй бичгийн журам, түүнд хамаарах 10 алхмыг зааж өгсөн, мөн хичээнгүй бичигт сургах гадаад хүчин зүйл буюу урьдчилсан нөхцөл болох зөв суух, дэвтрээ зөв тавих, үзгээ зөв барих, ширээ сандал тохирсон байх, зүг чигийн баримжаа олгох, харааны багтаамж сайжруулах дасгал, тэдгээрт холбогдох тайлбар, хичээнгүй бичигт сургах дотоод хүчин зүйл болох үсэг бүтээх үндсэн зурлага, цагаан толгойн үсгийн зурлагыг оруулж, хичээнгүй бичиг хичээлээр оюутны бичих чадварыг шалгах жишиг даалгаврыг тусгаж өгсөн байна.

Судлаач Нэргүйцэцэг.С нарын (2022) “Хичээнгүй бичиг” сурах бичигт хичээнгүй бичиг, түүнд холбогдох онолын үндэслэл, тухайлбал хичээнгүй бичигт сургаж ирсэн уламжлал, дэвтэрт хичээнгүй бичүүлэх аргууд, хичээнгүй бичгийн журам, алхмууд, дэвтэрт хичээнгүй бичүүлэх гадаад дотоод хүчин зүйл зэрэг, эдгээртэй холбогдох оюутны бие даан ажиллах даалгаврыг хамтатган оруулсан, мөн үсэг бүтээх үндсэн зурлага, цагаан толгойн үсэг, түүнд холбогдох онол ба дадлагыг тусгажээ.

Үндсэн хэсэг 1

Судалгаа I. Багш бэлтгэдэг сургуулийн сургалтын төлөвлөгөөнд анализ хийхэд 1954-1963 он хүртэл “Цэвэр бичиг” нэртэйгээр тусгагдаж, 1-р курсийн оюутнуудад ордог байсан бол 1964 оноос “Хичээнгүй бичиг” хэмээх нэрлэлт нэмэгдэж 1980 он хүртэл “Цэвэр бичиг”, “Хичээнгүй бичиг” гэсэн хоёр нэрлэлтээр 2 болон 3-р курст, 1981-2015 он хүртэл “Хичээнгүй бичиг” хичээл нь тасралтгүй 2, 3-р курст судалдаг байсан. 2016 оноос одоог хүртэл 2-р курсийн намрын улиралд 2 кредитийн хичээлээр тусгагдаж, ордог болсон байна. Багш бэлтгэх сургууль байгуулагдсан цагаас хойш сургалтын хөтөлбөрт “Хичээнгүй бичиг” хичээл тусгагдаж өнөөг хүртэл орж байгаа боловч багш, бага боловсролын оюутнууд хичээнгүй бичих чадварт ахиц гаргах шаардлагатай байгаа нь ажиглагддаг.

Иймээс, Багш, бага боловсролын оюутнуудын хичээнгүй бичих чадвар ямар түвшинд байгааг тодорхойлох зорилгоор дэвтрийн болон самбарын бичвэрийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан гарааны үнэлгээ хийж, дүгнэж үзвэл:

График 1. Дэвтрийн бичвэрийн судалгаа





График 2. Самбарын бичлэгийн судалгаа



Судалгаанд 2, 3-р курсийн 34 оюутан хамрагдсанаас маш сайн 4, сайн 6, дунд зэрэг 8, сайжруулах шаардлагатай 16 оюутан байна. Судалгаанаас үзвэл оюутнуудын дэвтэрт бичих чадварыг сайжруулах шаардлагатай болох нь харагдаж байна.

2, 3-р курсийн 34 оюутан хамрагдсанаас маш сайн 3, сайн 6, дунд зэрэг 10, сайжруулах шаардлагатай 15 оюутан байна. Судалгаанаас үзвэл оюутнуудын самбарт бичих чадварыг сайжруулах шаардлагатай болох нь харагдаж байна.

Үндсэн хэсэг 2

Багш, бага боловсролын оюутнуудын хичээнгүй бичих чадварт хийсэн гарааны үнэлгээнд тулгуурлан дараах үйл ажиллагааг төлөвлөж ажиллалаа.

Үйл ажиллагаа 1. Дэвтэрт хичээнгүй бичих чадварыг дэмжих

Оюутнуудын бичих чадварыг дэмжих зорилгоор Багш, бага боловсролын 3а, 3б ангиудад долоо хоног бүрийн пүрэв, баасан гарагт 1:30 минутаар “Хичээнгүй бичиг” –ийн хэв тигийг сайжруулах зорилгоор энгийн өгүүлбэрийг хичээнгүй бичүүлж, эхний 3 долоо хоногт өөрийн бичвэрийн тиг, том жижиг үсгийн

хэмжээ, үсэг хоорондын баримжааг тогтооход анхаарсан. Ингэснээр, оюутнуудын хичээнгүй бичгийн тиг, журмын дагуу бичих чадварт ахиц гарч, үсгийн хэмжээ, үсэг хоорондын зайг ижил хэмжээтэй бичих, орон зайн баримжаалал сайтай болж, улмаар бичгийн хэв тогтож эхэлсэн. Дараагийн 3 долоо хоногт бичих агуулгыг хүндрүүлэн 3 дахь долоо хоногт 1-2 өгүүлбэр, 4 дэх долоо хоногт 2-3 өгүүлбэртэй эх, 5 дахь долоо хоногт 3-4 өгүүлбэртэй эх бичүүлж, оюутнууд үсгийн налуу, үндсэн шугаманд хүргэх, үг хоорондын зайг баримжаалан бичихэд анхаарч бичлээ. Ингэснээр, оюутнууд хичээнгүй бичих явцдаа өөрсдийн алдааг хянаж, гаргасан алдаагаа засах, өөрийн бичвэрийг үнэлэх үнэлгээний арга зүйд суралцсан. Оюутнуудын түгээмэл гаргаж байсан үсгийн налууг тохируулах, үг хоорондын зайг жигд хэмжээтэй бичих чадвар долоо тутамд сайжирч, хичээнгүй бичгийн тиг журмын дагуу бичих чадварт суралцаж, хичээнгүй бичих чадварт ахиц гарч байлаа.

Үйл ажиллагаа 2. Самбарт хичээнгүй бичих чадварыг дэмжих

Багш, бага боловсрол мэргэжлээр сурч буй оюутнуудын зайлшгүй сурах чадварын нэг бол самбарт хичээнгүй бичих юм. Самбарт хичээнгүй бичих гарааны үнэлгээнд тулгуурлан, дэвтэрт хичээнгүй бичүүлэхээс гадна самбарт хичээнгүй бичих чадварыг хөгжүүлэхийг зорилоо. Самбарт хичээнгүй бичихийн өмнө шохой, урт шугам, самбарын алчуур бэлтгэсэн байна.

1. Самбарт үндсэн шугамыг зурж, шугамын дагуу хичээнгүй бичих дадлыг хийлээ. Эхлээд элементийн шугамаа зурна. Ингэхдээ шугам ашиглан, самбарт элементийн шугамыг хурдтай, зөв зурах чадварт суралцана. Бичихдээ үсгийн налуу, үсгийг хэрхэн бичих журмын дагуу зөв, хичээнгүй бичнэ.

Самбарт бичиж эхлэх үед шугам зурсан хэдий ч босоо бичих, үсэг хоорондын зайг тохируулахгүй байх зэрэг алдааг гаргаж байсан бөгөөд үндсэн шугамыг удаан зурах, шохойг даралттай бичихгүй байгаа нь ажиглагдсан. Үндсэн шугамыг татаж самбарт хичээнгүй бичих дадлыг хийснээр оюутнуудын бичгийн хэв тогтож, самбарт бичих чадвар сайжирсан. Шугам татаж хичээнгүй бичиж сурсны дараа үндсэн шугамыг татахгүй бичих үед мурий хазгай бичих, хэтэрхий том, жижиг бичих явдал элбэг тохиолддог.

2. Самбарт үндсэн шугамыг татахгүй хичээнгүй бичих дадлыг хийлээ. Шугамтай бичихдээ зөв, хичээнгүй бичдэг болсон ч шугам татахгүй бичих үед эхэндээ эмх цэгцгүй, том жижиг, мурий хазгай бичих, үсэг хоорондын хэмжээг алдаж бичих тохиолдлууд гарч байсан.

Самбарт үндсэн шугамыг татахгүй хичээнгүй бичих дадлыг хийснээр оюутнууд самбар төлөвлөлт (хаанаас эхлэн бичих, хэмжээ баримжаа) хийх чадвартай болж, самбарт хичээнгүй бичих чадвар илүү сайжирсан байна. Багш, бага боловсролын оюутнууд “Хичээнгүй бичих” чадвараа сайжруулахын тулд нэг цагийг самбарт болон дэвтэрт бичих чадвараа дэмжихэд зарцуулснаараа хичээнгүй бичгийн тиг, журмын дагуу бичих чадварт суралцах, өөрийн бичвэрт үнэлгээ хийх, засан сайжруулах, үнэлгээний арга зүйд суралцсан сайн талтай юм.

Үйл ажиллагаа 3. Оюутны хичээнгүй бичихэд гаргаж буй “Алдааны сан” бүрдүүлсэн байдал


Оюутнуудын бичвэрт долоо хоног тус бүрээр үнэлгээ хийж, оюутнуудын түгээмэл гаргаж буй алдаанд анализ хийж ажиллалаа. Хичээнгүй бичих явцдаа багш, бага боловсролын оюутнуудын гаргаж буй алдааг тэмдэглэн, “Алдааны сан” - г бүрдүүлээ.

График 3. Зурлагын алдааны сан бүрдүүлэлт



Графикаас харахад, оюутнууд эхний долоо хоногт дэгээ эхлэлтэй зурлага, орхиц төгсгөлтэй зурлага, дэгээ эхлэл орхиц төгсгөлтэй зурлага, дугуй зурлага, шулуун зурлага, гогцоо төгсгөлтэй зурлага, хөндлөн шулуун зурлагууд дээр ихэвчлэн алдаа гаргаж байсан бол 2-р долоо хоногоос үндсэн зурлагын алдаа багасч, дэгээ эхлэлтэй урт, богино зурлага, бүтэн зууван дугуй зурлага, гогцоо төгсгөлтэй урт богино зурлага дээр алдаа харьцангуй багассан. 3-р долоо хоногоос оюутнуудын үндсэн зурлага дээр гаргах алдаа эрс багасаж, тэдний бичвэрт ахиц гарч байгаа нь ажиглагдлаа.

График 4. Үсгийн бичвэрт гаргаж буй алдаа сан бүрдүүлэлт



Дээрх графикаас харахад, оюутнууд үсгийн холбон бичих явцдаа үсэг хоорондын зай, үсгийн налалт, үндсэн шугаманд хүргэх, дэвтрийн талбай ашиглалт дээр ихэнх оюутан алдаа гаргаж байсан. Нийт оюутнуудын бичвэрээс харвал үсгийг босоо болон хэт налуу бичих, үсэг хоорондын зайг ижил хэмжээтэй бичих зэрэг алдаануудыг ямар ч үсгэн дээр түгээмэл гаргадаг болох нь ажиглагдсан. 3-р долоо

хоногоос оюутнуудын гаргаж буй алдаа багасч, бичих чадварт ахиц гарч байна. Оюутан тус бүрийн бичвэрт үнэлгээ хийж ажилласнаар тэдний гаргаж буй алдааг нэг бүрчлэн хянах боломжтой юм. Оюутнуудын хичээнгүй бичих явцдаа гаргаж буй алдааг:

А. Оюутнуудын гаргаж буй нийтлэг алдаа


Б. Зарам нэг оюутны гаргаж буй алдаа гэж ангилан, цаашид засахын тулд анхаарах зүйлийг тусгаж өгөв.

Нийт оюутнуудын гаргаж буй алдаа нь шугамдаа хүрэхгүй байх, хэт босоо болон налуу бичих, хөндлөн богино шулууныг ташуу бичих, Г, Б, Т, Д үсгүүдийн эхний зурлагыг дээд хязгаарын шугаманд тулгаж бичих зэрэг алдаануудыг гаргадаг болох нь ажиглагдлаа.

Үйл ажиллагаа 4. Үлгэр жишээ хичээнгүй бичгийн сан бүрдүүлсэн байдал

Энэхүү судалгааны ажлаараа монгол хэлний судлагдахууны хүрээнд “Унших”, “Бичих”, “Ярих үйл” -ийг дэмжсэн үлгэр жишээ хичээнгүй бичгийн санг бүрдүүлж, “Оюутан-багш” болон ЕБС-ийн багш нар хичээл сургалтын үйл ажиллагаандаа бүтээлчээр ашиглах боломжтой хэрэглэгдэхүүнийг бэлтгэлээ.

Бүдүүвч 1. Үлгэр жишээ хичээнгүй бичгийн сангийн бүтэц:



Хүснэгт 1. “Эгшиг үсэг”-ийн үлгэр жишээ хичээнгүй бичгийн сан

Дд	Эгшиг авиа, үсэг	Төрөл, чиглэл	Тоо ширхэг
1.	Аа	а, аа, ай	Том, жижиг, богино, урт, хос эгшгийн хэрэглэгдэхүүн (7ш)
2.	Ээ	э, ээ, эй	
3.	Ии (й, ы)	и, ий, ы	
4.	Оо	о, оо, ой	
5.	Өө	ө, өө	
6.	Уу	у, уу, уй	
7.	Үү	ү, үү, үй	

Хүснэгт 2. “Гийгүүлэгч” үсгийн үлгэр жишээ хичээнгүй бичгийн сан

Дд	Гийгүүлэгч үсэг	Төрөл, чиглэл	Тоо ширхэг
1	1-р шатны гийгүүлэгч үсэг (Мм, Рр, Сс, Хх, Вв, Лл, Нн, Шш)	Битүү ба задгай үе	16
		Үг, холбоо үг	16
		Өгүүлбэр	8
2	2-р шатны гийгүүлэгч үсэг (Бб, Дд, Гг, Тт, Цц, Чч, Жж, Зз)	Битүү ба задгай үе	16
		Үг, холбоо үг	16
		Өгүүлбэр	8
3	Я-гийн төрлийн үсэг (Яя, Ее, Ёё, Юю)	Үг, холбоо үг	8
		Өгүүлбэр	4
4	Онцгой гийгүүлэгч үсэг (Кк, Пп, Фф, Шш)	Үг, холбоо үг	8
		Өгүүлбэр	4
Нийт хэрэглэгдэхүүн :			104

Хүснэгт 3. “Эх бичвэр”-ийн үлгэр жишээ хичээнгүй бичгийн сан дахь хэрэглэгдэхүүний тоо

Дд	Эх бичвэр	Төрөл, чиглэл	Тоо ширхэг
1	Бичил эх	Унших, бичих үйлийг дэмжихэд ашиглах боломжтой эхүүд	30
2	Аман зохиолын төрөл	Онъсого	10
		Таавар	10
		Зүйр цэцэн үг	10
Нийт хэрэглэгдэхүүн:			60

Судалгааны үр дүн

- Оюутнуудын хичээнгүй, зөв цэвэр бичих чадварыг дэмжсэнээр дэвтэрт болон самбарт “Хичээнгүй бичих” тигийн дагуу зөв, сайхан бичих чадварт ахиц гарч байгаа нь харагдаж байна.
- Оюутан бүр өөрийн бичсэн бичвэрт үнэлгээ хийх чадвартай болж, мөн засан сайжруулах үнэлгээний арга зүйд суралцсан.
- 4-р курсийн “Цагаан толгойн” дадлагад гарахад оюутнууд самбарт болон дэвтэрт хичээнгүй бичих чадвар дадлыг маш сайн эзэмшин гэж үнэлэгдсэн ахиц гарсан.
- “Үлгэр жишээ хичээнгүй бичиг”-ийн хэрэглэгдэхүүнийг багш мэргэжлээр суралцаж буй оюутнууд, ЕБС-ийн бага боловсролын багш нар сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр ашиглах боломжтой.

Дүгнэлт

1. Сурагчдыг хичээнгүй бичүүлэх нь багш бүрийн өдөр тутмын энгийн нэг ажил төдий санагдавч бичгийн соёл сургаж буй том ажлын нэг байдаг. Иймээс багш мэргэжлээр суралцаж буй оюутнууд хичээнгүй бичигт суралцах хэрэгцээ тулгарч байна.
2. Багш, бага боловсролын оюутнуудын хичээнгүй бичих чадварыг үнэлж, гаргаж буй алдааг тооцож, хичээнгүй бичгийн тиг журмын дагуу бичих чадварыг дэмжин ажиллахад “Хичээнгүй бичих” чадварт ахиц дэвшил гарлаа. Үүнд :
 - Оюутнууд хичээнгүй бичих явцдаа өөрсдийн алдааг хянаж, гаргасан алдаагаа засах, өөрийн бичвэрийг үнэлэх үнэлгээний арга зүйд суралцан, түгээмэл гаргаж байсан үсгийн налууг тохируулах, үг хоорондын зайг жигд хэмжээтэй бичих чадвар долоо хоног тутамд сайжирч, дэвтэрт хичээнгүй бичих чадварт дундажаар 90% -ийн ахиц гарч байлаа.
 - Самбарт хичээнгүй бичих дадлыг хийснээр зөв хичээнгүй бичих чадварт 85%-ийн ахиц гарч, самбар төлөвлөлт (хаанаас эхэлж бичих, хэмжээ баримжаа) хийх чадвартай болсон байна.
 - Оюутнуудын бичвэрт долоо хоног тус бүрээр үнэлгээ хийж, түгээмэл гаргаж буй алдаанд анализ хийж ажилласнаар тэдний гаргаж буй алдааг нэг бүрчлэн хянах боломжтой бөгөөд оюутан багш өөрийн гаргаж буй алдааг илрүүлж, засан сайжруулах, багшлах явцдаа сурагчдын гаргаж болзошгүй алдааг урьдчилан засах зэрэг олон давуу талтай юм.
 - Суралцагчдын хичээнгүй бичих чадварт ахиц гарч, монгол хэл судлагдахууны хүрээнд “Унших”, “Бичих”, “Ярих үйл” -ийг дэмжсэн үлгэр жишээ хичээнгүй бичгийн санг бүрдүүлж ажиллалаа. Үлгэр жишээ хичээнгүй бичгийн сантай болсноор оюутан багшийн хувьд ажлын байранд дээр гараад сурагчдынхаа хичээнгүй бичих чадварыг дэмжих бодит хэрэглэгдэхүүнтэй болсон зэрэг хэрэглээний ая холбогдолтой туршилт судалгаа боллоо.

Ном зүй

- Батсүрэн.С (2009). Хичээнгүй бичиг, Улаанбаатар.
- Бямбацэрэн.Г (2020). Эх хэлний цагаан толгойд суралцахуйн онол, арга зүй, Улаанбаатар.
- Лхаахүү.Г (2004). Хичээнгүй бичиг, Улаанбаатар.
- Лхаахүү.Г (1997).Хичээнгүй бичгийн дасгал ажлын дэвтэр, Улаанбаатар.
- Наранцэцэг.Ц (2007, 2014).Хичээнгүй бичгийн дасгал ажлын дэвтэр, Улаанбаатар.
- Наранцэцэг.Ц нар (2012). Хичээнгүй бичиг, Улаанбаатар.
- Нэргүйцэцэг.С, Наранчимэг. Б нар (2021). Хичээнгүй бичих, Улаанбаатар.
- Сүхбат.Б (1970). Хичээнгүй бичих заах гарын авлага, Улаанбаатар.
- Сэмжид.Б (1970). Хичээнгүй бичиг заах гарын авлага, Улаанбаатар.
- Шарав.С (1972). Хичээнгүй бичиг ажлын дэвтэр, Улаанбаатар.
- Цэдэнбал.Ч, Бямбацэрэн.Г нар (2010). Бага боловсролын монгол хэл, бичиг, уран зохиолын онол, дидактик, Улаанбаатар.
- Цэвэгжав.Б (1959) Цэвэр бичиг, Улаанбаатар.

EXPERIMENTAL TEACHING METHOD RESULT ON WORKING WITH TEXT

^aMunkhtuya B., ^bNaranchimeg B.
^aTeachers School in Arkhangai. MNUE;
^bTeachers School in Arkhangai. MNUE

Corresponding author: b_munkhtuya@msue.edu.mn 

Abstract

The purpose of the “Diligent Writing” course specified in the training plan of teacher training schools is to “provide a guaranteed level of preparation for the effective writing method that students should possess, and to prepare teachers who creatively use writing and teaching methods in their training.” within the scope of the purpose of clearly pointing out the knowledge, abilities and attitudes of the students, providing theoretical understanding, and doing more practical work, it shows the results of the new young teachers diligently understanding and learning about writing, and learning good writing skills. In today’s training, there are few books and manuals that have been elaborated in detail on the method of diligent and beautiful writing, only “Diligent Writing” books related to diligent writing have been published, which are used in educational activities. Also, due to the lack of textbooks that combine theory, methodology, and practice for students who are studying to be teachers and elementary school teachers of general education, we aim to study how students can develop their ability to write diligently independently.

Keywords

Stuent, diligent writing, writing skills, experiment, progress